



Эмэгтэйчүүдийн багц /алтан, 40–өөс дээш болон доош насны/ шинжилгээ өгөхийн өмнөх бэлтгэл

Шээсний шинжилгээний бэлтгэл:

- Гадна бэлэг эрхтэнг угааж арчсаны дараа ариутгасан зориулалтын савны тагийг зөвхөн шээх үедээ онгойлгож шээсний дунд хэсгээс өгнө.
- Шөнийн турш давсганд хуримтлагдсан өглөөний шээснээс зориулалтын ариун саванд авч 2 цагийн дотор лабораторит хүргэсэн байна.
- Хэрвээ 2 цагаас илүү хугацаагаар хадгалсан бол устгаж, эхний шээснээс хойш 2 цаг орчим давсганд хуримтлагдсан шээсний дунд хэсгээс дахин зориулалтын саванд авч өгнө.
- Шээсний ерөнхий шинжилгээний сорьцыг хөлдөөж болохгүй.

Цусны шинжилгээний бэлтгэл:

- Өлөн байх /8–12 цагийн турш хоол идээгүй болон газтай болон чихэрлэг ундаа, зөгийн бал болон чихэртэй цай уугаагүй байх/
- 72 цагийн өмнөөс архи согтууруулах ундаа, өөх тос ихтэй хоол хэрэглээгүй байх, витамин С, аспирин, уналт таталтын эсрэг эм, кафейны найрлагатай эм, бэлдмэл хэрэглээгүй байх, биеийн хүчний дасгал болон хэт ачаалал аваагүй байвал илүү тохиромжтой.

Дааврын шинжилгээ:

- 40–өөс доош насанд дааврын шинжилгээг сарын тэмдгийн 2–3 дахь өдөр өгнө.
- 40–өөс дээш насанд сарын тэмдгийн мөчлөг хамааралгүй өгч болно.

Ясны сийрэгжилтийн шинжилгээ:

- Хөлийн өсгий ясанд хийгддэг учир тирко өмсөхгүй, тайлахад хялбар байхаар оймс өмсөж ирнэ үү.

Мазок, умайн хүзүүний хавдрын эсийн шинжилгээ:

- Давсганд шээсгүй байх
- Сарын тэмдэг ирээгүй байх
- Өмнөх өдөр нь бэлгийн харьцаанд ороогүй байх
- Дотуур угаалга хийгээгүй байх

Жич: Дээрх шинжилгээний хариу гарсны дараа нэмэлт шинжилгээ шаардлагатай бол төлбөр тусдаа тооцогдоно.

Бусад нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлага гарвал 7 хоног дотор үзлэгийн төлбөрөөс 50%-ийн хөнгөлөлт эдлүүлнэ.